МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛАГУУДЫН ХОЛБОО

ЖИЛИЙН ТАЙЛАН
2019

УЛААНБААТАР ХОТ

МЭНДЧИЛГЭЭ



Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын Холбооны эрхэм гишүүд, энэ салбарт хамтран ажиллаж ирсэн нийт мэргэжилтэнгүүд, байгууллагууд та бүхний амрыг эрин мэндчилье.

2019 онд ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 1.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 445.2 тэрбум төгрөгөөр буюу 34.7 хувиар өсч, харилцагчдын тоо өмнөх оноос 78.2% хувиар нэмэгдэж 2.8 саяд хүрсэн, олон талаараа нийгэм эдийн засагт өндөр хувь нэмэр оруулсан санхүүгийн зах зээлд улам хүчирхэг салбар болжээ.

2019 онд Холбоо нь эрхэм зорилго, чиглэлийнхээ хүрээнд төлөвлөсөн ажил болон цаг үеийн тулгамдсан асуудлуудыг амжилттай шийдвэрлэж, гишүүдээ чадавхижуулж, нийгмийн хариуцлага, комплаенс, ёс зүйг дээшлүүлж, тогтвортой эрх зүйн орчинтой хөгжлийн асуудлуудад голлон анхаарч ажилласан байна. Үүний хүрээнд, гишүүдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж холбогдох төрийн захиргааны байгууллагууд, хуулийн этгээдүүдэд дангаар болон бусад төрийн бус байгууллагуудтай хамтран тулгамдаж байгаа асуудлуудыг хөндөж шийдвэрлүүлэх, хууль журмуудын төслүүдэд санал хүргүүлэх ажлуудыг шуурхай гүйцэтгэлээ.

Мөн нийт ББСБ-ын холбогдох ажилтнуудад “Комплаенс ба ёс зүй” сертификатжуулах онлайн сургалтыг амжилттай хүргэж, гишүүддээ мэргэжлийн сургалт, арга хэмжээнүүдийг зохион байгуулж, салбарын холбогдох мэдээллээр тогтмол хангаж, олон улсын байгууллагуудтай хамтран ажилсанг дурдахад таатай байна.

Дэлхий даяар санхүүгийн технологийн шинэ үе хөгжин тэлж байгаагийн хэрээр холбоо холбогдох хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, харилцагчийн болон байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэл технологийн компани болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллаж гишүүддээ шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний боломжуудыг нээн ажиллаж байна.

Холбоо ББСБ-уудын ёс зүйтэй үйл ажиллагааг дэмжин гишүүн байгууллагуудын баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг шинэчлэн баталж, ажилласан нь ахиц дэвшил авчирч байгааг харах таатай байна.

Нийт гишүүдийн сэтгэл ханамжийн судалгаагаар 2019 оны Холбооны үйл ажиллагааг өмнөх жилээс мэдрэгдэхүйц өндөрөөр үнэлсэн нь Удирдах зөвлөл болон Ажлын албыг улам ихийг хийж бүтээхийн урам өглөө.

Холбоо цаашид эрхэм зорилгынхоо хүрээнд эрх тэгш хүртээмжтэй үйл ажиллагааг эрхэмлэн ажиллах болно. Харилцагчийн эрэлтэд нийцсэн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, технологийн шийдлүүд, бичил санхүүгийн хүртээмжийг улам ихээр дээшлүүлэх ажлуудыг гишүүд болон хамтран ажилладаг байгууллагуудтайгаа мэргэжлийн ёс зүйтэй, зөв засаглал болон комплаенстайгаар хамтдаа шийдвэрлэх болно.

Бидний үйл ажиллагааг үргэлж дэмжиж, эрч хүч бэлгэлж ирсэн эрхэм холбооны гишүүд, хамт олон, хамтран ажилладаг байгууллагууддаа чинь сэтгэлийн талархал дэвшүүж ажил үйлс тань амжилт бүтээлээр дүүрэн байхыг хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн, Монголын ББСБ-уудын Холбооны ерөнхийлөгч З.Алтанзул

ХОЛБООНЫ ТУХАЙ

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо(МББСБХ) нь 2002 онд үүсгэн байгуулагдсан ба ББСБ-уудыг сайн дураар гишүүнчлэлдээ нэгтгэсэн, ардчилсан засаглалтай, бие даасан, ашгийн төлөө бус, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага юм.

МББСБХ нь сүүлийн 18 жилийн хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэн, тогтвортой явуулж ирсэн ба гишүүдийнхээ нийтлэг эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн хүсэл зоригийг төрийн эрх барих байгууллагын өмнө төлөөлөх, гишүүдийг зөвлөмж мэдээллээр хангах, боловсон хүчнийг сургах, эрх зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих, олон нийтэд сурталчлах, хууль хяналтын байгууллага, гадаад дотоодын харилцагч түншүүдтэй хамтран ажиллах, ББСБ-ын салбарыг хөгжүүлэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх зэрэг үндсэн чиглэлд үйл ажиллагаа явуулж байна.

Холбооны нийт гишүүд нь 2019 оны байдлаар салбарын нийт активын 65% нийт зээлийн 71% зээлдэгчдийн 86%, нийт салбарын ажиллагсдын 62%- ийг эзлэж байна.

АЛСЫН ХАРАА

Хүчирхэг бичил санхүүгийн үйлчилгээ болон түншлэлийн нэгдмэл байдлаар ядуурлыг бууруулж, Монгол орныхоо нийгэм, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол Улсын санхүүгийн зах зээлд эзлэж буй ББСБ-ын салбарын байр суурийг улам бэхжүүлэн хөгжүүлэх, олон улсын түвшинд гарган үйл ажиллагааг өргөжүүлэх замаар Монгол улсын нийгэм эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг улам дээшлүүлж, ядуурлыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, бичил болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчидэдбодит дэмжлэг үзүүлэхэд оршино.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- Гишүүдийн хууль ёсны эрх, нийтлэг ашиг сонирхолыг хуулийн хүрээнд төлөөлөн хамгаалах
- Салбарын стратеги, бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж ажиллах
- Төрийн болон олон улсын байгууллага, бусад холбогдох этгээдтэй хамтран ажиллах
- Гишүүн байгууллагын ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалт, семинар, уулзалтыг
- Төрийн болон Төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах
- Санхүүгийн салбарын холбогдолтой төрөл бүрийн мэдээллээр хангах,
- Мэдээллийн зохих санг буй болгох
- Гишүүн байгууллагын үйл ажиллагаа, нийгэмд оруулж буй хувь нэмрийг сурталчилах, олон нийтэд таниулах.

МБББСБ-ын ХОЛБООНЫ БҮТЭЦ

ХОЛБОО НЬ БҮХ ГИШҮҮДИЙН ХУРАЛ, УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ, ЕРӨНХИЙЛӨГЧ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, АЖЛЫН АЛБА ГЭСЭН ҮНДСЭН БҮТЭЦТЭЙ БАЙНА.

БҮХ ГИШҮҮДИЙН ХУРАЛ

Холбооны эрх барих дээд байгууллага нь Холбооны Бүх гишүүдийн хурал байх бөгөөд, Холбооны бүтэц зохион байгуулалт, дүрэм, жилийн төсвийг батлах, Хяналтын зөвлөлийн зөвлөлийн гишүүнийг сонгох, ажлын тайланг хэлэлцэх, дүгнэлт өгөх гэх мэт бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Бүх гишүүдийн хурлыг 2019 онд 1 удаа зарлан хуралдсан.

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

Хяналтын зөвлөл нь Холбооны дүрэм, Удирдах зөвлөл, Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавих, өмч хөрөнгийн ашиглалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх гэх мэт дүрэмд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүд гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй байна.

УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Удирдах Зөвлөл нь Холбооны үйл ажиллагааны ерөнхий стратеги төлөвлөгөөг хэлэлцэж батлах, Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, Ерөнхийлөгч, Гүйцэтгэх Захиралыг сонгох, чөлөөлөх түүний дор ажиллах ажлын албаны бүтэц зохион байгуулалт төсөв, тайланг хэлэлцэх батлах эрхийг хэрэгжүүлнэ.

Мөн холбооны гишүүдийг шинээр элсүүлэх, чөлөөлөх, гишүүдийн татвар төлөх журмыг тогтоох, ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих эрхийг хэрэгжүүлж байна. Удирдах зөвлөлийн хурал 2019 онд 9 удаа хуралдсан.

ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

Холбооны Ерөнхийлөгч нь Холбооны Удирдах зөвлөлийн хурлыг даргалах, Холбоог гадаад, дотоодод төлөөлөх, Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн холбооны гүйцэтгэх захиралтай хөлсөөр ажиллах гэрээ байгуулж ажилуулах, дүгнэх, Удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулах, бэлтгэлийг хангуулах эрхийг хэрэгжүүлнэ.

ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Гүйцэтгэх захирлыг Удирдах зөвлөлийн хурлаас 2 жилийн хугацаагаар томилон ажиллуулж болох бөгөөд улируулан томилж болно.

Гүйцэтгэх захирал нь Холбооны ажлын албыг удирдах, Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, Улиралд нэг удаа Холбооны үйл ажиллагааны явцын талаар Удирдах Зөвлөлд илтгэн тайлагнах, шаардлагатай бол Зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулж ажиллаж байна.

МБББСБ-ЫН ХОЛБООНЫ БҮТЭЦ



Холбооны эрх барих дээд байгууллага нь Бүх гишүүдийн хурал бөгөөд гишүүдийн төлөөллөөс бүрдсэн Удирдах зөвлөлийн 13 гишүүн, Хяналтын зөвлөлийн 3 гишүүн, үйл ажиллагааны байнгын 5 хороо, 1 түр хорооны бүтэцтэй байна. Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг Удирдах зөвлөлөөс гаргасан тогтоол, шийдвэр, өгсөн чиглэлийн дагуу гүйцэтгэх захирлаар удирдуулсан ажлын алба явуулж байна.

Холбооны дүрмийн дагуу удирдах зөвлөлийг 2 жилийн хугацаатайгаар, хяналтын зөвлөлийг 3 жилийн хугацаатайгаар бүх гишүүдийн хурлаас томилдог. Холбооны ерөнхийлөгчийг Удирдах зөвлөлийн гишүүдээс 3 жилийн хугацаатайгаар томилдог.

ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

“ТӨР, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА”

Гишүүн байгууллагуудын Монгол Улсын нийгэм, эдийн засагт оруулж буй үр нөлөөг дээшлүүлэх, сурталчилах, төрөөс баримтлах бодлогыг хамтран хэрэгжүүлэх болон бусад ТББ болох МҮХАҮТ, УБХТ болон хувийн хэвшлийн байгууллагауудтай хамтын ажиллагаагааа өргөжүүлэн ажиллаж байна.

СЗХ-той “Харилцан ойлголцлын санамж бичиг” болон ”Мэргэшүүлэх, Чадавхжуулах” сургалтын гэрээг байгуулан хамтран ажиллаж байна.

Тогтвортой санхүүжилт /ТОС/-ын үйл ажиллагааны талаар мэдээлэл цаг алдалгүй авч, шаардлагатай уулзалт, семинарт оролцож байна.

Банк санхүүгийн академи /БСА/–тай “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулсан

Зээлийн батлан даалтын сан /ЗБДС/-тай хамтын ажиллагааг эхлүүлсэн.

Холбоо нь “Frankfurt School of Finance & Management”-тай хамтын ажиллагааны гэрээ байгууллаа. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд тус байгууллагаас зохион байгуулагддаг сургалт, хөтөлбөрүүдэд гишүүн ББСБ-ууд 10% хөнгөлөлт эдлэх боломжтойгоос гадна сертификатжуулах шалгалтын Монгол дахь албан ёсны төлөөлөгч боллоо. Ингэснээр өмнө нь Бээжинд очиж шалгалт өгч, сертификат авдаг байсан төлөөлөгчид маань Монголдоо Холбоогоор дамжуулан өгөх боломжтой болсон.

Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох, Мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай, ААНОАТатварын тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, хуулийн төсөлд гишүүн ББСБ-ууд болон МҮХАҮТ, УБХХТ, АмЧам, Европын сэргээн босголт хөгжлийн банк бусад донор байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байр сууриа төрийн эрх бүхий байгууллагуудад хүргэх, ОУ-ын туршлагыг танилцуулах арга хэмжээнүүдийг хийж хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж ажилласан.





“ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН”

Банк бус санхүүгийн салбарын үйл ажиллагааны талаарх хууль тогтоомж, бодлого, зохицуулалтын шийдвэр, эрх зүйн актын төсөлд санал өгөх, гишүүдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн оролцож СЗХ, Монголбанк зэрэг зохицуулагч байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

ББСҮА-ны тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр ЕСБХБ, СЗХ-той хамтран ажилласан.

Гишүүн байгууллагуудын хүсэлтээр дүрмийн санг нэмэгдүүлэх хугацааг хойшлуулах саналыг СЗХ-нд тавьж хугацааг 1 жилээр сунгасан.

Эрх зүйн бусад орчиныг бүрдүүлэх хүрээнд “ААНОАТХууль”, “ЗХДХТМХТХууль” зэрэг хуулиудад саналаа өгч, байр суурия идэвхитэй илэрхийлж оролцсон.

“ГАДААД ХАРИЛЦАА”

Гишүүн ББСБ-уудыг олон улсын чуулга уулзалт, сургалт, семинарт хөнгөлөлттэй үнээр хамруулах, техникийн болон мэдээлэл, арга зүйн туслалцаа авах, хөрөнгө оруулагч болон зээлжих зэрэглэлийн үнэлгээ хийгч байгууллагуудтай холбоо, харилцаа тогтоох, улмаар санхүүжилт татах боломжуудыг бий болгоход “Frankfurt school of Finance”, ЕСБХБ, ОУСК, АХБ, МикроФинанза рейтинг зэрэг байгууллагуудтай техникийн туслалцаа, санхүүжилт, сургалт, зөвлөгөө мэдээлэл авах чиглэлд хамтран ажиллаж байна.





Турк улсад болсон олон улсын “Цахим бичил санхүү”-ийн чуулга уулзалтанд Холбоо болон гишүүн ББСБ-уудын нийт 14 төлөөлөл оролцсон.

“СУРГАЛТ, БОЛОВСОН ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ”

ББСБ-ын салбарын боловсон хүчнийг чадавхижуулах зорилгын хүрээнд сургалтын чиг үүргийг Холбоо хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд стандарт, хэрэгцээт, гадаад гэсэн үндсэн гурван төрлийн сургалтуудыг зохион байгуулж байна.

1 СУРГАЛТ

“Комплаенс ба Ёс зүйн” онлайн сургалт нь 7 ээлжээр явагдаж 371 ББСБ-ын **530** ажилтан хамрагдсан байна.

2 СУРГАЛТ

Мэргэшүүлэх, чадавхжуулах 8 төрлийн 16 удаагийн сургалт төлөвлөгдсөнөөс 7 төрлийн 12 удаагийн сургалт явагдаж **300** хүн хамрагдсан

3 СУРГАЛТ

Хэрэгцээт сургалт 5 төрлийн 5 удаагийн сургалт төлөвлөгдсөнөөс 2 төрлийн 2 удаагийн сургалт явагдаж **32** хүн хамрагдсан.

Banking & Finance Academy
МЭДЛЭГ ТҮГЭЭНЭ МАНЛАЙЛАЛД ХӨТӨЛНӨ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Frankfurt School of Finance & Management
German Excellence. Global Relevance.





“ПРОГРАММ ХАНГАМЖ, ТЕХНОЛОГИЙН САЙЖРУУЛАЛТ”

Гишүүн байгууллагуудын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцлийг дэмжихийн тулд гадаад дотоодын программ хангамжийн компаниудтай хамтран ажилладаг.

- Гадаад, дотоодын программ хангамжийн компаниудтай хамтран 2 удаагийн уулзалт, өдөрлөг зохион байгуулаа.
- “ASPEKT” “Fern” компанитай хэлэлцсэний үр дүнд МББСБХолбоо дээр ирж танилцуулга хийхээр боллоо.
- ХУР системд нэгдсэн байдлаар холбогдоход ББСБ-уудад дэмжлэг үзүүлж, шаардлагатай уулзалт, тодруулгыг хийж ажиллаа.
- ЗМС-тай холбоотой асуудлаар гишүүн байгууллагуудад цаг үеийн мэдээллийг өгөх, шаардлагатай 2 удаагийн уулзалт зохион байгуулж, санал хүсэлтүүдийг хүргэж ажилла.
- ECM компаниар ЗМС-д холбогдох программ хийлгэж, нэвтрүүлэхэд бэлэн боллоо.
- АХБ-ны “The Unlocking Innovation Project” хүрээнд “Core System”, үйл ажиллагааны модулийг хөгжүүлэх хүрээнд хамтран ажиллахаар боллоо.
- Грэйпсити Монгол ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулаа. Уг гэрээний зорилго нь Холбооны гишүүн ББСБ-д Поларис системийг үнийн хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлж, программ хангамжийн шинэчлэл, өөрчлөлтийг цаг тухай бүрт нь хийх зорилготой.

“НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА”

Гишүүн ББСБ-уудын үйл ажиллагааг олон нийтэд эергээр таниулах, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор Холбоо нь нийгэмд чиглэсэн олон үйл ажиллагааг зохион байгуулдаг. 2019 онд “1000 цүнх” хандивын аян, Цусаа бэлэглэх “Амьдрал бэлэглэе” аян, “Бяцхан санхүүч миний хуримтлал” бүтээлийн уралдаан зэргийг зохион байгуулсан.



Банк бус санхүүгийн байгууллагын ажилтануд цусаа бэлэглэх **“АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЭ”** аянд нэгдлээ.



Монголын ББСБ-уудын Холбооноос Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран “ББСБ-уудын дунд цусаа бэлэглэх сайн үйлсийн аян”-ыг зохион байгуулсан. Аянд нийтдээ 20 ББСБ-ын 260 ажилтан хамрагдаж, 350 нэгж цус цуглуулснаар, 500 хүнийг эмчлэх, тэдэнд амьдрал бэлэглэх үйлсэд хувь нэмрээ оруулаа.



Хандивын аян **4** дэх жилдээ зохион байгуулсан ба **38** ББСБ нэгдэн орлцож **1014** хүүхдэд цүнх хандивласан.





Гишүүн ББСБ-уудын ажиллагсад, харилцагчдын хүүхдүүдийн дунд **4** дэх жилдээ “Миний мөрөөдөл” сэдвээр явагдсан гар зургийн уралдаанд, **100** гаруй хүүхдүүд бүтээлээ ирүүлж амжилттай зохион байгуулсан.



Эдгээрээс гадна гишүүн ББСБ-уудтай хамтран харилцагчдын эрх ашгийг хамгаалах хөдөлгөөн /Smart-campaign/-д нэгдэн, /ToC/ зарчмууд болон ББСБ-уудын үйлчилгээний стандартыг сайжруулах, хэрэгжүүлэх чиглэлд хамтран ажиллаж, хариуцлагатай санхүүгийн үйлчилгээг хүргэх зорилгоор ажиллаж байна. Мөн бусад мэргэжлийн холбоодуудтай хамтарч салбарын нийгмийн хариуцлагын хүрээнд олон ажилууд зохион байгуулдаг.

“ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА, ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА”

Банк бус санхүүгийн салбарын эв нэгдэл, байгууллага болон боловсон хүчний багийн ажиллагааг дэмжих,хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх спортын болон бусад үйл ажиллагааны төрөлд өрсөлдөх боломжийг бүрдүүлж, салбарын шилдэгийг шалгаруулдаг.





• ШИЛЖИН ЯВАХ ЦОМ-ын ээзд Жуниор натур инвестмент ББСБ, Про кредит ББСБ, Төв хөгжил ББСБ хамтын баг шалгарсан

• “Бичил Глобус Финанс” ББСБ-тай хамтран Волейбол, ширээний теннисний тэмцээнийг зохион байгуулж 35 ББСБ оролцсон.

“Өв соёлоо дээдэлцгээе” уриан дор Бичил Глобус финанс ББСБ-тай хамтран Гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж 35 ББСБ оролцсон.

Эмэгтэй “гар бөмбөг” төрлийн 2019 оны аваргаар:
I байр: Есөн шижир инвест ББСБ
II байр: Бичил глобус финанс ББСБ
III байр: Жуниор натур инвестмент ББСБ, Про кредит ББСБ, Төв хөгжил ББСБ /хамтарсан/

Эрэгтэй “гар бөмбөг” төрлийн 2019 оны аваргаар:
I байр: Жуниор натур инвестмент ББСБ, Про кредит ББСБ, Төв хөгжил ББСБ /хамтарсан/
II байр: Жи Эс Би капитал ББСБ
III байр: ВишнФанд ББСБ

“Монголын санхүүгийн групп ББСБ”-тай хамтран Сагсан бөмбөгийн аврга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж 28 ББСБ оролцсон.

Эрэгтэй “Сагсан бөмбөг” төрлийн 2019 оны аваргаар:
I байр: Монголын санхүүгийн групп ББСБ
II байр: Уянга жи эс эс ББС, Батжин нэгдэх үрс ББСБ /хамтарсан/
III байр: ЛэндМН

Эмэгтэй “Сагсан бөмбөг” төрлийн 2019 оны аваргаар:
I байр: Монголын санхүүгийн групп ББСБ
II байр: Бичил глобус финанс ББСБ
III байр: ЛэндМН

МББСБХОЛБОО НЬ ШИНЭ ОНЫ БОСГОН ДЭЭР ОНЫ ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГУУДАА ШАЛГАРУУЛАХ “АЛТАН ОД” ХҮНДЭТГЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛДАГ. ЭНЭХҮҮ АРГА ХЭМЖЭЭНД НИЙТ 250 ГАРУЙ ЗОЧИД ТӨЛӨӨЛӨГЧИД ОРОЛЦОЖ ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИН ХАМТДАА ОНЫ ШИЛДГҮҮДЭЭ ШАЛГАРУУЛЛАА.

2019 ОНЫ ШИЛДЭГЭЭР ДАРААХ БАЙГУУЛЛАГУУД ШАЛГАРСАН

ОНЫ ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГААР:

ТРАНСКАПИТАЛ
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ХӨГЖИЛ ФИНАНС
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ОНЫ ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ БАЙГУУЛЛАГААР:

MobiFinance

ОНЫ ШИЛДЭГ САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙГУУЛЛАГААР:

ЦЕНТРАЛ КАПИТАЛ
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

СЭКЮР ФИНАНС

ОНЫ ШИЛДЭГ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГААР:

ИВЭЭЛ ИНВЕСТ ББСБ

OCHIRUNDRAA
Source for your success
OMZ





“СУДАЛГАА, ТАЙЛАН МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ”

Холбоо нь гишүүддээ олон улсын болон дотоодын эдийн засаг, банк санхүүгийн салбарын холбогдолтой төрөл бүрийн мэдээ мэдээллийг цаг тухайд нь оновчтой хүргэх, олон улсын банк, санхүүгийн байгууллагын тэргүүн туршлага, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, санхүүгийн салбарын өнөөгийн болон хэтийн төлөв байдлын талаарх судалгаа тайланг боловсруулан түгээж, холбооны гишүүдийн хооронд үр ашигтай мэдээллийн системийг бүрдүүлж харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг ажлуудыг гүйцэтгэдэг.


САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ БА ТҮҮНИЙ НӨЛӨӨЛӨЛ





• Холбооны үйл ажиллагааны талаар цахим хуудас, нүүр номонд мэдээлэл тогтмол хүргэж байна.
• СЗХ-ны “Хүртээмжтэй санхүү“ сэтгүүлд Холбооны ерөнхийлөгчийн ярилцлага нийтлэгдсэн.
• “Investor Nation” форумд холбооны ерөнхийлөгч оролцож ББСБ-ын салбарын талаар болон Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох хуулийн төслийн хүрээнд байр сууриа илэрхийлж оролцсон.
• Салбарын нэр хүндэд сөргөөр нөлөөлөхүйц мэдээ, мэдээлэл гарсан үед шаардлагатай тайлбар, мэдэгдэлийг тухай бүр олон нийтэд түгээж ажиллаа.
• Холбооны танилцуулгыг гадаад, дотоодын хамтран ажилладаг байгууллагуудад зориулж Англи, Монгол хэл дээр хэвлэгдсэн.
• Mongolian Economy сэтгүүлийн тавдугаар сарын дугаарт зээлийн хүүд дээд хязгаар тогтоох асуудлууд, Банк санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал болон Холбооны ерөнхийлөгчийн ярилцлага нийтлэгдсэн.

СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ НЭГТГЭЛ

Холбооны гишүүн ББСБ-уудад чиглэсэн ажил, шинэ санал, санаачлагыг идэвхижүүлэх, холбооны үйл ажиллагаанд үнэлгээ өгөх гишүүн ББСБ-уудаас сэтгэл ханамжын судалгаа авав.

Судалгаанд холбооны гишүүн 122 ББСБ хамрагдсан бөгөөд зээл, төлбөрийн баталгаа гаргах, мөнгөн гуйвуулгын үйлчилгээтэй, гадаад валют арилжаа, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх зэрэг тусгай зөвшөөрөл бүхий ББСБ-ууд хамрагдсан.

СТРАТЕГИ БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ БАЙГАА ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

Холбооны стратеги бодлогын ажлуудад нийт ББСБ-ын 69.2% нь сайн ба маш сайн гэж дүгнэсэн ба өмнөх оны судалгаа нь 67% байсан үнэлгээ нь 2.2%-иар өссөн байна.



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

Сургалт, олон нийтэд чиглэсэн ажлуудад 79.5% нь сайн ба маш сайн гэж дүгнэсэн ба өмнөх оны судалгааны үнэлгээ 71% байсан нь 8.5%-ийн өсөлтийн үнэлгээтэй байна.



МАРКЕТИНГ, ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭНД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

Олон нийтэд чиглэсэн ажлуудад 70% нь сайн ба маш сайн гэж дүгнэсэн ба өмнөх оны судалгааны үнэлгээ 71% байсан нь 1%-иар буурсан үнэлгээтэй байна.



МБББСБХ-НЫ ЗАХ ЗЭЭЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ БОЛОН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ЦАГ ТУХАЙД НЬ ХАНГАЛТТАЙ ХҮРГЭЖ БАЙГАА ЭСЭХД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ.

Холбооноос мэдээ, мэдээлэл түгээх ажлын хувьд 71.3% нь Маш сайн ба сайн мэдээлэл өгдөг гэж үзсэн бол 27% нь дундаж, 1.6% нь муу гэж үзжээ. Холбооны зүгээс цаашид мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэх, мэдээллийн сайтуудыг шинэчлэх сайжруулах, стратеги бодлого, хууль тогтоомж үйл ажиллагааны мэдээллийг оновчтой хүргэхээр төлөвлөн ажиллаж байна .



МБББСБХ-ООС ГИШҮҮН ББСБ-УУДТАЙ ХАРИЛЦАА ХОЛБООТОЙ АЖИЛЛАЖ, САНАЛ БОДЛЫГ СОНСОЖ НИЙТЛЭГ ЭРХ АШГИЙГ ХАМГААЛЖ ЧАДАЖ БАЙГАА ЭСЭХД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

Гишүүн ББСБ-уудын дуу хоолойг сонсож байгаа байдал нийтлэг эрх ашгийг хамгаалж байгаа байдлын хувьд 62% нь Маш сайн ба сайн явагдаж байна гэж үзсэн нь өмнөх оны үзүүлэлтээс 11%иар өссөн үзүүлэлтэй байна.



ГИШҮҮН ББСБ-ЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ /ХУВИАР/

2019 оны жилийн эцсийн байдлаар нийт харилцагчдын тоо өмнөх оноос 78.2%-иар өсөж 2,8 саяд хүрсэн ба Гишүүн ББСБ-ын хувьд 2.6 сая нийт зах зээлийн 92%-ийг эзэлж байна.



УЛАМЖЛАЛТ БОЛОН ФИНТЕК ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ 2019 /ТООГООР/

2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 538 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа ба Уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа 527 ББСБ-ууд байгаа ба энэ нь нийт зах зээлийн 98%-ийг эзэлж байна.

Финтек зах зээлийн хувьд санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж үйл ажиллагаа явуулж буй ББСБ тоо 11 байгаа нь зах зээлийн 2%, Зээлдэгчдийн 63.3%, нийт зээлийн 18%, мөнгөн хөрөнгийн 7.6%-ийг эзэлж байна.



ЗЭЭЛДЭГЧИЙН ТОО

ФИНТЕК	265,500
УЛАМЖЛАЛТ	154,354



НИЙТ ЗЭЭЛ /ТЭРБУМ/

ФИНТЕК	223.0
УЛАМЖЛАЛТ	1,010.1



ББСБ-ЫН ТОО

ФИНТЕК	11
УЛАМЖЛАЛТ	527



МӨНГӨН ХӨРӨНГӨ /САЯ/

ФИНТЕК	27.5
УЛАМЖЛАЛТ	336.5

БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХУРААНГУЙ

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны хуульд заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ууд нь үндсэн 9 төрлийн үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлж байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн зах зээлд нийт 538 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагийн 91.6 хувь нь буюу 494 ББСБ зээлийн үйл ажиллагаа, 29 хувь нь буюу 156 ББСБ гадаад валютын арилжааг дагнан болон хавсран эрхэлж байна.

ББСБ-ууд нь Санхүүгийн зохицуулах хороонооос авсан 11 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд санхүүгийн тайланг улирал бүр хүргүүлж, зайны болон газар дээрх хяналтын хүрээнд ажилладаг.

ББСБ-уудын байршил

Монгол улсын 21 аймагт ББСБ-ын үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч дийлэнх 464 ББСБ буюу 86.2 хувь нь нийслэл Улаабааатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна. Орон нутгийн хэмжээнд нийт 74 ББСБ иргэдэд банк бус санхүүгийн үйлчилгээг хүргэж байна. Дараах зурагт ББСБ-уудын байршлын тархалтыг Монгол улсын газрын зураг болон графикаар үзүүллээ.



ББСБ-ын тархалт, 2019 он



Улсын хэмжээнд тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхэлж буй 538 ББСБ нийт 250 салбартай. Холбооны гишүүн ББСБ хувьд 167 нь Улаанбаатар хотод 23 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаагаа эрхэлж байна.

Улаанбаатар Хөдөө орон нутаг

ББСБ-УУДЫН ТОО /ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР/

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/

493	ЗЭЭЛ	
156	ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА	
34	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР ЗӨВЛӨГӨӨ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ	
34	ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	
31	ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦОО, МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ	
29	ФАКТОРИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	
20	ТӨЛБӨРИЙН БАТАЛГАА ГАРГАХ	
10	БОГИНО ХУГАЦААТ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ	
4	ТӨЛБӨР ТООЦООНЫ ХЭРЭГСЭЛ ГАРГАХ	

ӨӨРИЙН БОЛОН НИЙТ ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ



ЗӨЗЛИЙН 1 САРЫН ХҮҮ



ББСБ-ЫН ХҮРТЭЭМЖ, ХҮН АМЫН ҮЗҮҮЛЭЛТЭЭР

ББСБ-уудын нийт харилцагчдын 53 хувь нь эмэгтэй, 47 хувь нь эрэгтэй байна. Нийт зээлдэгчдийн дийлэнх буюу 58.2 хувь нь дээд боловсролтойиргэд эзлэж байна



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗЭЭЛДЭГЧИД /БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР/



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗЭЭЛДЭГЧИД /НАСНЫ БҮЛГЭЭР/



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАРИЛЦАГЧИД



ББСБ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

Салбарын зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор ББСБ-уудын зээлийн үйлчилгээний хүртээмж сайжирсан бөгөөд салбарын харилцагчдын тоо өмнөх оноос 78.2%-иар нэмэгдэж 2.8 саяд хүрсэн байна. Үүнийг дагаад нийт зээлийн өсөлт өмнөх оноос 41.9%-иар өсөж 1.2 их наяд хүрсэн өсөлттэй байна.2019 оны байдлаар 2962 ажилтан албан хаагч ажиллаж байна.

НИЙТ ЗЭЭЛ ӨСӨЛТ



2019 онд салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 41.9 хувиар өссөн дүнтэй байна.

ХАРИЛЦАГЧДЫН ТОО, ӨСӨЛТ



2019 онд харилцагчдын тоо өмнөх оноос 78.2% хувиар нэмэгдэж 2.8 саяд хүрсэн байна.

АЖИЛЧДЫН ТОО



2019 онд ажилчдын тоо өмнөх оноос 6.4% хувиар нэмэгдэж 2962 ажилтантай байна.

ББСБ-ЫН САЛБАРЫН НИЙТ ХӨРӨНГӨ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ӨГӨӨЖ /ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/

НИЙТ ХӨРӨНГӨ



2019 онд нийт хөрөнгө 1,7 их наяд хүрсэн нь өмнөх оноос 446 тэрбум буюу 34,6%-иар өссөн ба нийт хөрөнгийн өгөөж 10% хүртэл өссөн байна.

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ



2019 онд өөрийн хөрөнгө 1,2 их наяд хүрсэн нь өмнөх оноос 284 тэрбум буюу 29%-иар өссөн ба өөрийн хөрөнгийн өгөөж 11% хүртэл өссөн байна.

УЛААНБААТАР ХОТ, СҮХБААТАР ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО
СӨҮЛИЙН ГУДАМЖ, ТҮШИГ ТӨВ 5 ДАВХАР, 509 ТООТ
77008380
INFO@BBSB.MN
WWW.BBSB.MN
МББСБ ХОЛБОО